

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2016 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

1. Бүтэц, орон тоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.1-д заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжаар “Нийслэлийн Дотоод аудитын алба”-ыг Санхүүгийн аудитын хэлтэс, Гүйцэтгэлийн аудитын хэлтэс, Чанарын хяналтын хэлтэс, Захиргаа, хуулийн хэлтэс гэсэн 4 хэлтэстэй, 18 албан хаагчтай байгуулагдсан. Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийг Сангийн яаманд шилжүүлсэнтэй холбоотойгоор Нийслэлийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/975 дугаар захирамжаар нийт 22 албан хаагчтайгаар 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл ажиллаж ирсэн. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдөж, 18 албан хаагчтайгаар тайлант оныг дуустал ажиллалаа.

Тус байгууллага нь төрийн захиргааны байгууллагынхаа хувьд өдөр тутмын үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Архивын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулиуд болон эдгээр хуулиудыг дагаж мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актууд мөрдөн ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагаа болох дотоод аудитын үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”, Сангийн сайдын баталсан Санхүүгийн хяналт шалгалтын стандарт, аудит хийж буй байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой салбарын хуулиуд болон эдгээр хуулиудыг мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актуудыг мөрдөн ажилладаг.

Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар Санхүүгийн хяналт шалгалтын стандарт батлагдсан, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор байгууллагын дүрмийг шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд албан хаагчдад тэтгэмж, дэмжлэг, урамшуулал олгох, сургалтын төлбөр төлөх, ажлаас чөлөөлөх, ажилд томилох зэрэг хүний нөөцтэй холбоотой байгууллагын даргын 33 тушаалыг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэн гаргасан байна.

2016 онд байгууллагын дарга 4 нэгжийн даргатай, нэгжийн дарга нар нийт 16 албан хаагчтай үр дүнгийн гэрээ, 1 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд оны эхний хагас жилд нийт 21, бүтэн жилээр 17 албан хаагчийн ажлын үр дүнг дүгнэж үнэлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс гаргасан зааврын дагуу орлогч даргын ажлын байрны тодорхойлолтыг шинээр, Захиргаа, хуулийн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдөн ажилласан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн програмд шинээр мэдээллийн бааз үүсгэн оруулсан бөгөөд нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг тухай бүр цаг хугацаанд нь гаргаж өгсөн.

Тус байгууллагад 2016 онд иргэдээс ирсэн 29 өргөдлийн 28 нь байгууллагын албан хаагчдын гаргасан өргөдөл, хүсэлт байсан. Эдгээрийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 11 цаг 42 минут, индекс 0.883, үнэлгээ А байгаа нь өмнөх оныхоос 16 хоногоор бага, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дунджаас 0.044 нэгжээр дээгүүр байна.

2. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварын нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, 2016 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 2016 оны төсөвт 10.0 сая төгрөгийг батлуулж, давхардсан тоогоор нийт 108 албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулснаас 16 албан хаагчийн сургалтын төлбөрт 4,650.0 мянган төгрөг зарцуулсан. Тухайлбал:

- Компанийн засаглалын сургалтад 7 албан хаагч,
- СЯ-ны Дотоод аудитын эрчимжүүлсэн сургалтад 13 албан хаагч,
- Захиргааны ерөнхий хуулийн сургалт 22 албан хаагч,
- Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах тухай" сургалтад 22 албан хаагч,
- ММНБИ-ийн Аудиторын сургалтад 2 албан хаагч,
- Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтад 1 албан хаагч,
- Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулдаг хуульчийн үргэлжилсэн сургалтад 1 албан хаагч,
- НЗДТГ-ын ХЭЗХ-ээс зохион байгуулсан УИХ-аас сүүлийн үед баталсан хуулиудын танилцуулга сургалтад 1 албан хаагч,
- Авлигын эсрэг хуулийн сургалтад 1 албан хаагч,

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтад 1 албан хаагч,
- Өргөдөл, гомдол хариуцсан ажилтны сургалтад 1 албан хаагч,
- Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээс зохион байгуулсан жилийн эцсийн аудитын сургалтад 1 албан хаагч,
- Цахим төсөв сургалтад 1 албан хаагч,
- Шилэн дансны мэдээллийн нэгдсэн цахим системийн сургалтад 1 албан хаагч,
- Архивын програмын болон архивын ажилтны сургалтад 1 албан хаагч,
- Албан хэрэг хөтлөлтийн шинэ програмын сургалтад 3 албан хаагч,
- Аудитын E-AUDIT програмын сургалтад 22 албан хаагч,
- НЗДТГ-ын ТЗУХ-ээс зохион байгуулсан байгууллагын удирдлага, хүний нөөц, ЭБАТ-уудад зориулсан цуврал сургалтад тус бүр 1,
- Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээс зохион байгуулсан жилийн эцсийн аудитын сургалтад 1 албан хаагч,
- Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээс зохион байгуулсан санхүү, төсвийн талаар баримтлах бодлого чиглэл, цаашид анхаарах асуудлууд сургалтад 4 албан хаагч,
- Сангийн яам, Японы ЖАЙКА төсөл хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын зааварлагч” бэлтгэх сургалтад албан хаагчид оролцож, зохих шалгалтыг өгснөөр 7 албан хаагч зааварлагч болж гэрчилгээ авсан.
- Олон улсын дотоод аудитын институтын Удирдах зөвлөлийн дарга асан Филип Тарлингийн дотоод аудитын талаар уншсан хүндэтгэлийн лекцэнд 3 албан хаагч,
- Монголын Үндэсний дотоод аудиторчуудын холбооны өглөөний цуврал уулзалт-сургалтад 9 албан хаагч,
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын VI их хуралд Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, аудитор Д.Лувсанчимэд нар төлөөлөгчөөр сонгогдон оролцлоо.

3. Албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлын үр дүнг үнэлэх, ажлын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр:

Байгууллагын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2016 онд 21,700.00 мянган төгрөгийн төсөв батлуулсан. Албан хаагчдын ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 4 албан хаагчид нийт 1,634.00 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгосон. Хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагчдын 34 хүүхдэд 1,071.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн.

Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлаас чөлөөлөгдсөн 3 албан хаагчид үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж болох 5,299.9 мянган төгрөг олгосон.

Санхүүгийн аудитын хэлтсийн аудитор Б.Уранбилэгт “Улаанбаатар орон сууц сан”-аас орон сууцны урьдчилгаа төлбөрийн 50 хувь болох 10.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчийг тангарагийг шинээр 2 албан хаагч өргөсөн. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинээр 4 албан хаагчид олгож, 2 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг ахиулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагч ахиулж, 1 албан хаагч шинээр авлаа.

Мөн 8 албан хаагч санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрх авч, үүнтэй холбоотойгоор 4 албан хаагчийн албан тушаалын ангилал өссөн.

2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21 албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж, хагас жилийн ажлын үзүүлэлтээр нийт албан хаагчдын 16 буюу 76 хувь нь А, 5 буюу 24 хувь нь В үнэлгээ авч, нийт 11,139.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, байгууллагын 2015 оны төсвийн урамшууллын 70 хувь болох 8,223.7 мянган төгрөг албан хаагчдад тус тус олгосон. Жилийн эцсийн байдлаар 17 албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэснээс албан хаагчдын 14 буюу 82 хувь нь А, 3 буюу 18 хувь нь В үнэлгээ авч, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, аудитор Ц.Дуламдорж, Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Б.Отгонцэрэн нар байгууллагын оны шилдэг ажилтнаар, Захиргаа, хуулийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн байгууллагын шилдэгийн шилдэг ажилтнаар шалгаруулж, 1,233.2 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан “Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу байгууллагын 2015 оны төсөв хэмнэсний урамшууллын 8.2 сая төгрөгийг албан хаагчдад олгосон.

Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан, болзол шаардлагыг хангасан 1 албан хаагчийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 4 албан хаагчийг Сангийн яамны “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 2 албан хаагчийг Сангийн яамны Жуух бичгээр шагнуулахаар тодорхойлсон. Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны үр дүнгээр нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудыг манлайлж, “Бүрэн хангалттай” үнэлүүлсний урамшуулалд удирдлагын багт 4,500.0 мянган төгрөг олгосноор байгууллага, хамт олноороо Хэнтий аймгийн нутгаар “Их түүхийн мөрөөр” эко тойрон аялал зохион байгуулсан.

Байгууллагын дэргэдэх биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг дэмжин “Эрүүл ажлын байр” хөтөлбөр батлан хэрэгжүүлж эхэлсэн. Бүх албан хаагчдыг 4,988.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулсан. Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор ажлын байрны дасгалыг өдөр бүр хийж, долоо хоног бүрийн мягмар гарагт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын “Сүлд” спорт хорооны зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэж байна “Эрүүл агаар-рио

2016” сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн арга хэмжээ, байгууллагын 2 жилийн ойд зориулан боулинг, олс таталтын тэмцээн зохион байгуулсан. Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэл, дүүргийн Дотоод аудитын албадын дунд явагддаг спортын уламжлалт тэмцээнд амжилттай оролцож, манай гар бөмбөгийн холимог баг 1-р байр эзэлж, хошой аварга баг болсон. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд “Улаанбаатар марафон 2016” олон улсын гүйлтийн тэмцээнд 14 тамирчин сонирхогчдын төрөлд оролцлоо.

Хавар, намрын бүх нийтийн их цэвэрлэгээ, цас цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, мод тарих ажилд зориулж 105.0 мянган төгрөгийн хандив цуглуулах ажлыг зохион байгуулсан.

4. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах чиглэлээр:

Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог нийт албан хаагчдаас авсан нууц санал хураалтын дүнг үндэслэн 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажилласан.

Ёс зүйн хороо нь нийт албан хаагчдад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм”, “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”, “Дотоод аудиторын ёс зүйн олон улсын стандарт”-ыг албан хаагчдад таниулан мөрдөн ажиллаж байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар нэг иргэнээс албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол ирснийг журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, хариуг иргэнд хүргэсэн. Байгууллагын удирдлагын санаачлагаар олон нийтийн ажил тасалсан хоёр албан хаагчийг ёс зүйн хорооны хурлаар оруулж, цаашид дахин ийм зөрчил гаргахгүй байхыг анхааруулж, сахилгын шийтгэл оногдуулахаас татгалзсан дүгнэлт гарган байгууллагын даргад танилцуулсан.

Нийслэлийн авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажилласан. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу давхардсан тоогоор 14 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 103 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэн, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн.

5. Дүгнэлт

Нийслэлийн Дотоод аудитын хорооны хурлаар Нийслэлийн Дотоод аудитын албаны 2015 оны аудитын жилийн төлөвлөгөөгөөр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын

нэгдсэн тайланг авч хэлэлцээд аудитын ажлын үр дүнг Нийслэлийн Дотоод аудитын хороонд “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэсэн.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын албаны даргатай байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг 2016 оны 1 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” гэж үнэлсэн.

2016 оны 6 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Сангийн яам, ЯОУХАБ-ын (JICA) Дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх төсөл хамтран зохион байгуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон харьяа байгууллагуудын 250 гаруй дотоод аудиторуд оролцсон “Улсын салбарын дотоод аудиторудын нэгдсэн зөвлөгөөн”-ий үеэр манай байгууллага дотоод аудитын үйл ажиллагааны сайн туршлагаа танилцуулсан нь зөвлөгөөнд оролцогчдын талархлыг ихээр хүлээж, Сангийн яамнаас онцгойлон талархал илэрхийлэн албан бичиг ирүүлж, бидний ажлыг өндрөөр үнэлсэн.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ

2017 оны 01 дүгээр сарын 04